
303

# ХУЛД СУМЫН СОЁЛЫН ТӨВИЙН ТҮҮХЭН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Дундговь аймгийн Хулд сумын Соёлын төв нь анх 1942 онд Улаан гэр нэртэйгээр бөөрөн хэлбэртэй байгуулагдаж “Живаа хүү” нэрт анхны ший жүжгийг дэглэн тавьсан.



1961 онд клуб болон өргөжин 100 хүний суудалтай анхны чулуун байшин нутгийн иргэдийн хамтын хөдөлмөрөөр баригдсан. Цаашид их засвар хийж орон нутаг судлах танхим хэлбэрээр ашиглах боломжтой.



2010 оны 7 сард нийт 432 м2 талбай, 1358,87 м3 эзлэхүүнтэй, нийт 9 өрөөтэй нам даралтын зуухаар халаадаг 2 дахь барилга ашиглалтад орсон



2020 онд Аймгийн ОНХС-ийн 54,8 сая төгрөгний санхүүжилтээр барилгын гадна, болон халаалтын их засварыг хийж өнгө үзэмж, үйлчилгээний орчиноо сайжруулсан.

# СОЁЛЫН ТӨВИЙН БҮТЭЦ ОРОН ТОО





**ЭРХЭМ ЗОРИЛГО**

- Эрин үеийн хөгжлийн түвшинд хүрсэн мэдээлэл, соёл гэгээрлийн төв болно

**АЛСЫН ХАРАА**

- Гоо сайхан, ёс зүйн өндөр хүмүүжилтэй иргэдийг төлөвшүүлнэ

# БИДНИЙ БАРИМТЛАХ ЗАРЧИМ

Ардчилсан шударга ёс, хүний эрх, эрх чөлөө, тэгш байдлыг хангах

Байгууллагын хөгжилд иргэн бүр хувь нэмрээ оруулах, манлайлах нөхцөлийг бүрдүүлэх

Төрийн болон төрийн бус байгууллага, бизнесийн түншлэл, хамтын ажиллагааг бэхжүүлэх

Нөхцөл байдлын өөрчлөлтөд уян хатан зохицох чадамжтай болох

Хариуцлага хүлээх чадвар, ил тод байх явдлыг хэм хэмжээ болгон ажиллана

# ХАМТ ОЛНЫ АМЖИЛТ

Манай хамт олон ямарваа арга хэмжээг зохион байгуулахад хэдий чинээ зүрх сэтгэлээ зориулж, хэр их хөдөлмөрлөж чадна төдий чинээ чанартай сайн болно гэсэн зарчмын дор гар,сэтгэл нийлэн ажиллаж зохих амжилтуудыг гаргаснаар дараах шагналыг хүртлээ

- 2005 онд “Хүүхдэд ээлтэй хамт олон”
- 2014 онд “Сумын тэргүүний хамт олон
- 2014 “Эрүүл мэндийг дэмжигч байгууллага”
- 2014 оны “Тэргүүний шилдэг менежер”
- 2014 онд “Амьдралын тохилог орчин”
- 2016 онд “Санаачлагч хамт олон”
- 2017 онд “Сумын тэргүүний хамт олон
- 2021 онд “Улсын жишиг” соёлын төв